



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.08.20 № 1131/2220
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолтой холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг Танд хүргүүлж байна.

Хавсралт 03 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255012979

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2025 оны 02 сарын 20-ны өдрийн
101/4561 дугаар албан бичгийн
хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ЗОЛЖАРГАЛААС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД
ТАВЬСАН АСУУЛТЫН ХАРИУ**

1.Төсвийн хөрөнгөөр гадаад улсаас “хөх нүүрсээр хийсэн шахмал түлш” худалдан авах тухай ТТТХХК/20250102556 дугаартай тендер нь Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолын 16 дугаар заалттай нийцэж байгаа эсэх

Дээрх асуулттай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 01/4561 дугаартай албан бичгээр дараах мэдээлэл ирүүлсэн. Үүнд:

“Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл болон 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу “Тавантолгой түлш” ХХК нь 2025 оны 02 дугаар сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрчим хүчний баяжуулсан нүүрсийг татан авч, сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэн, туршилтын ажлыг Шинжлэх ухааны академи, Хими, химийн технологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, итгэмжлэгдсэн лаборатори (ТТРС, АЛС, Ашигт малтмал, газрын тосны газар, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар)-уудад шинжлүүлэхээр хүргүүлсэн.

Шинжилгээгээр баяжуулсан нүүрсээр хийсэн шахмал түлшний үзүүлэлтүүд MNS5679:2022 стандартын техникийн шаардлагыг хангаж байгаа боловч хаягдал утаанд хийсэн шинжилгээгээр хүхэрлэг хий (SO_2), угаарын хийн (CO) агуулга MNS5216:2016 стандартын шаардлагыг хангаагүй. (Хүхэрлэг хийн агууламж дунджаар 1,985 мг/м³ үзүүлэлттэй)

Лабораторийн шинжилгээний дүнгээс харахад шахмал түлшинд агуулагдаж буй нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн хэмжээ 1.4 дахин их гарч, “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх түвшинг хангахгүй байгааг тогтоосон.

Улмаар Монголын ашигт малтмалын баяжуулагчдын холбооны дүгнэлт, зөвлөмж, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн зөвлөмж, мөн Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2025-2026 оны галлагааны улиралд импортын бэлэн түлшийг хэрэглэгчдэд зориулан жижиглэн савлах чиглэл өгсний дагуу “Тавантолгой түлш” ХХК нь компанийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, мөнгөн урсгал, зорилтот түвшний төлөвлөгөөнд холбогдох өөрчлөлтийг оруулан компанийн Дотоод аудитын газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороогоор хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 22 дугаар тогтоолоор импортын бэлэн түлш худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Мөн түүхий эдийн туршилтын тайланг холбогдох байгууллагад (Эрчим хүчний яам, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, “Эрдэнэс Тавантолгой”

ХК, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын хэсэг, Монголын ашигт малтмалын баяжуулагчдын холбоо) хүргүүлсэн болно.”

Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолыг мөн оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд уг тогтоолд “16” гэсэн заалт байхгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

2. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 5 дахь заалт Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолтой нийцэж байгаа эсэх

1. Дээрх асуулттай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 01/3635 дугаартай албан бичгээр дараах мэдээлэл ирүүлсэн. Үүнд:

“Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 5 дахь заалт нь Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалтад “түүхий нүүрсийг ахуйн зориулалтаар хэрэглэхээс татгалзаж, цахилгаан, газрын гүний дулаан, хагас коксон болон хийн түлшийг ашиглах” гэж, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт “агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт “Агаарын бохирдол, физикийн сөрөг нөлөөлөл нэмэгдсэн шалтгааныг тогтоох, хохирлыг арилгах арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, мэргэжлийн алба, бүх шатны Засаг дарга, холбогдох эрүүл ахуйн болон бусад байгууллага хамтран яаралтай авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасантай нийцэж байгаа болно.

Улсын Их хурлын 2025 оны 53 дугаар тогтоолын 11-д “агаар бохирдуулж байгаа аливаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөр, иргэн, аж ахуйн нэгжид төрөөс татаас, урамшуулал олгохгүй байх санхүүгийн механизмыг бүрдүүлэх, төсвийн хөрөнгөөр зуух, яндан, түлш зэрэг агаарын бохирдлын эх үүсвэрийг санхүүжүүлэхгүй байх, чанар, стандартын шаардлага хангасан утаагүй шахмал болон хийн түлшний үйлдвэрлэл, худалдааг хувийн хэвшлийн санаачилгад тулгуурлан зах зээлийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах” гэж, 12-т “хатуу түлшний хэрэглээг халах ажлыг зохион байгуулахдаа стандартын шаардлага хангасан дулаалга, цахилгаан халаалт, хий, бусад түлшийг ахуйн орчин нөхцөлд нь эрсдэлийн болон өртөг, үр ашгийн үнэлгээг хийж, иргэд өөрсдөө сонгох эрхтэй байхаар зохицуулах” гэж тус тус заасан боловч 2025-2026 оны халаалтын улиралд “Энержи ресурс” ХХК-ийн Ухаа худгийн мидлингийг шахмал түлшинд ашиглахгүй болсон, эрчим хүчний эх үүсвэрээр 100 хувь хангах боломжгүй зэрэг асуудалтай холбогдуулан Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг хангах түлшний эх үүсвэрийг боломжит нөхцөлөөр яаралтай сонгож, түлшний эх үүсвэрийг санхүүжүүлэх шаардлага тулгараад байна.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжээс хийж байгаа бүх төсөл, арга хэмжээг судлан үзэж, боломжтой төслүүдийг нэвтрүүлэх бүх санал, санаачилгыг дэмжин ажиллаж байна. Одоогийн байдлаар шахмал түлшний утааны бохирдлыг бууруулах цацлага, түргэн асаагчийг хэрэглэх талаар ирүүлсэн 3 төслийг хянан үзэж, “Тавантолгой түлш” ХХК-ийн шахмал түлшинд турших ажлыг хийсэн бөгөөд хувийн хэвшлийн зүгээс утаагүй шахмал түлш үйлдвэрлэх болон нийлүүлэх санаачилгыг ирүүлээгүй байна.”

2.Харин Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 01/4561 дугаартай албан бичгээр дараах мэдээлэл ирүүлсэн. Үүнд:

“Улсын Их Хурлаас 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталж, мөрдүүлж байгаа Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтад “Засгийн газар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан, агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгаан эрчим хүч, хийн түлшний үнийн урамшууллын хэлбэр, хувь хэмжээг тогтоох, урамшууллыг улсын төсвөөс санхүүжүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад “Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага агаар хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх” гэж тус тус хуульчилсан бөгөөд Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоол нь дээрх хуулийн зохицуулалтаас өөрөөр зохицуулсан байна.”

3.Улсын Их Хурлын 2025 оны 53 дугаар тогтоолын 15 дахь заалтад нийцүүлэн Үндэсний хороог шинэчлэн зохион байгуулахаар төлөвлөж байгаа эсэх

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 211 дүгээр тогтоолоор агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд уг тогтоолд Засгийн газрын 2025 оны 57 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайд ахлан ажиллахаар болсон.

---oOo---